

**“КЕНГУРУ” ОЛОН УЛСЫН МАТЕМАТИКИЙН УРАЛДААНЫ
ЖИШИГ БОДЛОГУУД**

(Монгол улсын ЕБС-ийн 3-4-р анги)

Түвшин: *Ecolier*


1) $2001 + 2002 + 2003 + 2004 + 2005 = ?$

- A) 1015 B) 5010 C) 10150 D) 11005 E) 10015

2) Маша охин дүүгээ төрөхөд 4 настай байжээ. Харин тэр энэ жил 9 настай. Тэр дүүгээсээ хэдэн насаар эгч вэ?

- A) 4 B) 5 C) 9 D) 13 E) 14

3) Зураг дээр A хотоос B хот руу хүрэх замыг үзүүлсэн ба CD замыг засварлах болсноос тойруу замаар явах болжээ. Тойруу зам нь хэдэн километр урт вэ?



- A) 3 B) 5 C) 6 D) 10 E) тооцох боломжгүй

4) Аль хариулт нь $671 - 389$ тооны ялгавраас ялгаатай вэ?


- A) $771 - 489$ B) $681 - 399$ C) $669 - 391$
D) $1871 - 1589$ E) $600 - 318$

5) Утсан дээр хэсэг шувууд сууж байв. Гэтэл тэдний тав нь нисээд явчихав. Хэсэг хугацааны дараа гурван шувуу буцан ирлээ. Ингэхэд тэнд 12 шувуу болжээ. Анх хэдэн шувуу байсан бэ?

- A) 8 B) 9 C) 10 D) 12 E) 14

6) Аль тоонууд нь гурвалжны гадна, тэгш өнцөгт болон тойргийн дотор оршиж байна вэ?

- A) 5 ба 11 B) 1 ба 10 C) 13
D) 3 ба 9 E) 6, 7 ба 4




7) “Өнгөт” гудамжны байшингууд 1 – 5 хүртэл тоогоор дугаарлагдсан ба байшин тус бүр хөх, улаан, шар, ягаан, ногоон өнгөтэй.



- улаан байшин зөвхөн хөх байшинтай зэргэлдээ
- хөх байшин улаан ба ногооны дунд нь орших бол 3 дугаартай байшин ямар өнгөтэй вэ?



A) хөх B) улаан C) шар D) ягаан E) ногоон

8) Хар ба цагаан өнгө тэнцүү байхын тулд хэдэн нүдийг харлуулах хэрэгтэй вэ?




A) 2 B) 3 C) 4
D) 6 E) 7

9) А – Е хүртлэх тэгш өнцөгтийн алийг нь өгсөн зурагтай давхцуулбал тэгш өнцөгт бүхэлдээ хар өнгөтэй болох вэ?




10) Дараах зураг дээр байгаа жин тус бүрийн ачаанууд тэнцүү болно. Жин дээр харандаа ба балнууд байна. Тэгвэл бал хэдэн грамм жинтэй вэ?



A) 6 B) 7 C) 8 D) 9 E) 10

11) Би ханан дээр дөрвөн цаг байрлуулав (Зураг).

Эдгээрийн зөвхөн нэг нь зөв явж байгаа. Бас нэг нь 20 минутаар түүрүүлж, дараагийнх нь 20 минутаар сүүлдэж, өөр нэг цаг нь бүүр зогссон байгаа бол одоо цаг хэд болж байна вэ?



A) 4:45 B) 5:05 C) 5:25
D) 5:40 E) 12:00

12) Тэргэл төрсөн өдрийн үдэшлэгт зорилуж сагс дүүрэн алим, жүрж авчирчээ. Зочид алимны хагасыг, жүржийн гуравны нэгийг идсэн бол сагсанд үлдсэн жимсний хэмжээ дараах хариунуудаас аль нь үнэн бэ?

- A) бүх жимсний хагас
 - B) бүх жимсний хагасаас их хэсэг
 - C) бүх жимсний хагасаас бага хэсэг
 - D) бүх жимсний гуравны нэг
 - E) бүх жимсний гуравны нэгээс бага хэсэг
-

13) Амар нэгэн тоог 10-аар үржихийн оронд 10-т хуваажээ. Ингэхэд 600 гарав. Хэрвээ тэр буруу бодоогүй бол хэд гэсэн хариу гарах байсан бэ?

- A) 6 B) 60 C) 600 D) 6000 E) 60000
-


14) Мандах зарим хуудаснууд нь урагдаж алга болсон нэгэн ном олжээ. Тэр номоо нээхэд зүүн хуудас нь 24, баруун тал нь 45-р хуудас байв. Тэгвэл энэ хоёрын хооронд хэдэн хуудас энэ номноос урагдаж алга болсон бэ?

- A) 9 B) 10 C) 11 D) 20 E) 21
-

15) Бат найз Болдоос 52 өдрийн өмнө төрсөн. Бат төрсөн өдрөө энэ жилийн 3 сард мягмар гаригт тэмдэглэжээ. Тэгвэл энэ жил Болд хэд дэхь өдөр төрсөн өдрөө тэмдэглэсэн бэ?


- A) даваа B) мягмар C) лхагва D) пүрэв E) баасан
-

16) Зурагт өгсөн квадратын нүднүүдэд тоонууд байрлуулсан бөгөөд эхний мөрөнд тоонуудын нийлбэр 3, хоёр дахь мөрөнд тоонуудын нийлбэр 8, эхний баганан дахь тоонуудын нийлбэр 4-тэй тус тус тэнцүү бол хоёр дахь багананд байх тоонуудын нийлбэрийг олно уу?




- A) 4 B) 6 C) 7 D) 8 E) 11
-

17) Кубын талсуудыг гурван өөр өнгөөр будсан байна. Энэ кубын талс бүр нэг өнгөтэй, хоёр эсрэг талсууд нь ижил өнгөтэй. Дараах зургаас аль нь энэ куб бэ?



- 18) Дөрвөн ширхэг квадрат хэлбэртэй хавтанг зураг дээрхийн адил байрлуулжээ. Хоёр хавтангийн талуудын уртыг зурагт өгсөн байна. Тэгвэл хамгийн том хавтангийн талын урт нь хэд вэ?



- A) 24 B) 56 C) 64 D) 81 E) 100


- 19) Маша, Мишагийн ангийн охид, хөвгүүд жагсав. Тэгэхэд Машагийн баруун талд 16 сурагч байсан ба тэдний дунд мөн Миша зогсож байв. Харин Мишагийн зүүн талд 14 сурагч байсан ба тэдний дунд Маша ч бас байлаа. Маша, Мишагийн хоёрын дунд 7 сурагч зогсож байсан бол энэ анги нийт хэдэн сурагчтай вэ?

- A) 37 B) 30 C) 23 D) 22 E) 16

- 20) 10 оронтой тооны цифрүүдийн нийлбэр нь 9. Тэгвэл энэ тооны цифрүүдийн үржвэр нь хэд вэ?

- A) 0 B) 1 C) 45 D) $9 \times 8 \times 7 \dots 2 \times 1$ E) 10

- 21) Том куб нь 125 ширхэг хар ба цагаан кубаас бүтнэ (зураг). Аль ч хоёр зэрэгцээ кубууд өөр өөр өнгөтэй. Том кубын оройнууд нь хар өнгийн куб бол хэдэн ширхэг цагаан өнгийн куб том кубад байна вэ?



- A) 62 B) 63 C) 64 D) 65 E) 68

- 22) Сугалаа 4 долларын үнэтэй. А, Б, В гэсэн гурван хүүхэд хамтарч хоёр сугалаа худалдан авчээ. Ингэхдээ А нь 1 доллар, Б нь 3 доллар, В нь 4 доллар өгсөн. Тэдний худалдан авсан нэг сугалаа нь 1000 доллар хожив. Үүнийгээ тэд сугалаанд оруулсан мөнгөний хэмжээгээр хувааж авсан бол Б-д хэдэн доллар ногдсон бэ?

- A) 300 B) 375 C) 250 D) 750 E) 425

- 23) D баг гурван удаагийн хөл бөмбөгийн тэмцээнд 3 гоол оруулж, 1-ийг хаалгандаа алджээ. Тоглолт бүрт хожвол 3 оноо, хайнцвал 1 оноо, хожигдвол 0 оноо авдаг ажээ. Тэгвэл тэдний энэ гурван тоглолтонд авсан оноотой тэнцүү биш байх тоо аль нь вэ?

- A) 7 B) 6 C) 5 D) 4 E) 3

- 24) Зургийн цагаан нүд бүрт саарал нүдэнд байх хоёр тоонууд үржвэрийг бичнэ. Жишээ нь $42 = 7 \cdot 6$. Зарим тоонуудыг үсгээр тэмдэглэсэн байна. Ямар хоёр үсэг ижил тоог илэрхийлж байна вэ?

| | | | | |
|---|----|----|---|----|
| • | | | | 7 |
| | J | K | L | 56 |
| | M | 36 | 8 | N |
| | T | 27 | 6 | P |
| 6 | 18 | R | S | 42 |

- A) L ба M B) T ба N C) R ба P D) K ба P E) M ба S